

## Аттестатчилал явуулах тухай

“Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-ын дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1.8 дахь заалт, Байгууллагын үйл ажиллагааны 2018 оны төлөвлөгөөний 9 дүгээр хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ажилтан нарын мэргэжлийн ур чадварын түвшин тогтоох аттестатчиллыг 2018 оны 12 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсугай.

2. Аттестатчиллын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй баталсугай.

Аттестатчиллын комиссын ахлагч:

Д.Алтангэрэл

Ахлах мэргэжилтэн

Гишүүд:

С.Отгонбаатар

Хуулийн зөвлөх

Д.Оюунсүрэн

Хөрөнгө оруулалт, олон нийттэй

харилцах харилцаа хариуцсан

мэргэжилтэн

3. Аттестатчиллыг хавсралтанд заасан “Аттестатчиллын журам”-ын дагуу зохион байгуулсугай.

4. Аттестатчиллыг үр дүнтэй зохион байгуулж үр дүнг удирдлага, хамт олонд танилцуулж ажиллахыг Аттестатчиллын комист /Д.Алтангэрэл/-д даалгасугай.

ДАРГА

Ч. ЭЛБЭГСАЙХАН

“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН АЖИЛТНУУДААС АЖИЛ  
МЭРГЭЖЛИЙН ЧИГЛЭЛЭЭР АВАХ АТТЕСТАТЧИЛЛЫН ШАЛГАЛТЫН ЖУРАМ

2018 оны 12 дугаар сарын 13-ны өдөр

Багануур дүүрэг

1. Аттестатчиллын шалгалтыг 2018 оны 12 дугаар сарын ... өдөр ... цагаас ҮТП-ийн захиргааны байранд явуулна.
2. Аттестатчиллыг Газрын даргын тушаалаар томилогдсон 3 хүний бүрэлдэхүүнтэй шалгалтын комисс авна.
3. Шалгалт авах үндсэн чиглэлүүдийг комисс гаргаж нийт ажилтнуудад 20 хоногийн өмнө хүргэсэн байна.
4. Шалгалтын 10 билетийг /билет бүр нь 6 асуулттай/ нууцлалтай боловсруулах бөгөөд амаар авна. Битүүмжилсэн билетийг шалгалт авахын өмнө нээнэ.
5. Ширээн дээр шалгалтанд бэлтгэх цэвэр цаас байна.
6. Шалгалт өгч байгаа ажилтан билетийн асуултад тодруулга авах эрхтэй.
7. Шалгалтын явцад гарч орох, ярих, хуулбарлахыг хориглоно.
8. Шалгалтын журам зөрчсөн хүнийг танхимаас гаргах эрхийг комисс эдэлнэ.
9. Шалгалтанд бэлтгэх хугацаа 30 минут байх бөгөөд тэмдэглэл хөтлөхийг зөвшөөрнө. Тэмдэглэлийг комисст хураалгана.
10. Комиссын гишүүн хүсвэл ажил төрлийн холбогдолтой нэмэлт асуулт тавьж болно.
11. Комиссын гишүүн билетийн асуултын хариулт бүрт 1-5 хүртэл тоогоор оноо өгч, хүн бүрт математик дунджаар үнэлгээ гаргана.
12. Нэг хүний үнэлгээг гишүүдийн үнэлгээний дунджаар гаргана.
13. Комисс нь аттестатчиллын дүнг нэгтгэж паркийн удирдлага болон нийт ажилтнуудад танилцуулна.

Журам боловсруулсан:

Д.Алтангэрэл /Ахлах мэргэжилтэн/